



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 04 өдөр

Дугаар A/53

Жаргалант

Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн
сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/180 дугаар захирамж, Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/15 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутагт дэвсгэрт байгаа мал, амьтныг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах төлөвлөгөөт арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн графикт хугацаанд сумын хэмжээнд чанартай зохион байгуулж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд даалгасугай.

3.Угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах мал, амьтдын тоог хавсралтаар баталсугай

4.Малчид, мал бүхий иргэдийг татан оролцуулж зарлан мэдээлэх, арга хэмжээний өмнө хашаа, хоолойг бэлтгүүлэх ажлыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр хангах, уг арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийж, заавар журмыг баримтлаагүй малчин, мал бүхий иргэд, холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (О.Банхар)-д даалгасугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Шижирмөнх)-д, гүйцэтгэлийг 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч (О.Банхар)-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501125

Сумын Засаг даргын 2025 оны 04 дугаар
сарын 04 -ний өдрийн А/Б дугаар
захирамжийн хавсралт



ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ
АРГА ХЭМЖЭЭД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО

№	Мал төрөл	Туулгалт	Угаалга	Боловсруулалт	Бүгд
1	Үхэр	3000	11000	4000	18000
2	Хонь	30000	55000	25000	110000
3	Ямаа	13000	25000	11000	49000
4	Нохой	160	0	0	160
Нийт		46160	91000	40000	177160

Сумын Засаг дарга
[Signature]
[Signature]
[Signature]